

**"Оюутан төвтэй, бүтээлч байдал ба
хүсэл тэмүүллийг эрхэмлэсэн их сургууль"**



(www.cdu.ac.kr)

2027 ОНЫ ГАДААД ОЮУТНЫ ХАВРЫН ЭЛСЭЛТ

**-ШИНЭ ЭЛСЭЛТ БОЛОН ШИЛЖИН СУРАЛЦАХ
ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ-**

2026. 7.

**ЧОДАНГ ИХ СУРГУУЛЬ
CHODANG UNIVERSITY**

Агуулга



Үндсэн мэдээлэл

1. Элсэлт авах сургууль, элсүүлэх оюутны тоо.....	1
2. Элсэлтийн хуваарь	2
3. Тавигдах шаардлага	3
4. Бүртгүүлэх арга	4
5. Сонгон шалгаруулах арга	5
6. Бүрдүүлэх материал.....	5
7. Элсэгчийн анхаарах зүйлс	6
8. Сургалтын төлбөрийн буцаан олголт	7
9. Бусад мэдээлэл	7



Хавсаргах маягтууд

(Маягт 1) Бүрдүүлэх материалын жагсаалт (шинээр элсэгч, шилжин элсэгч).....	8
(Маягт 2,3) Элсэлтийн анкет (шинээр элсэгч, шилжин элсэгч).....	9-10
(Маягт 4) Хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах зөвшөөрлийн хуудас.....	11-12
(Маягт5) Хувийн танилцуулга, суралцах төлөвлөгөө.....	13
(Маягт 6) Санхүүгийн батлан даагчийн тодорхойлолт.....	14

■ ШИНЭ ЭЛСЭГЧ

Сургууль	Элсүүлэх мэргэжил	Сургалтын хэлбэр	
		Солонгос хэлний хөтөлбөр	Англи хэлний хөтөлбөр
ОЛОН УЛС СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	Солонгос хэл судлалын мэргэжил	●	
	Олон улсын соёл аялал жуулчлалын мэргэжил	●	
	Глобал химийн инженерчлэл ба машин механизмын мэргэжил	●	
	Спорт, эрүүл мэндийн удирдлага мэргэжил	●	
	Глобал бизнесийн удирдлага мэргэжил	●	●
	Урлаг, дизайны мэргэжил	●	

※ Дээрх элсэлт авах мэргэжлүүд өөрчлөгдөж болох бөгөөд өөрчлөлт гарсан тохиолдолд элсэлтийн мэдээллийг сургуулийн вебсайтад зарлан мэдээнэ.

※ Элсэлтийн тоонд хязгаарлалтгүйгээр сонгон шалгаруулж болох боловч суралцахад хүндрэлтэй гэж үзсэн тохиолдолд шалгаруулалтаас хасагдаж болно.

■ ШИЛЖИН СУРАЛЦАГЧ

Сургууль	Элсүүлэх мэргэжил	Сургалтын хэлбэр	
		Солонгос хэлний хөтөлбөр	Англи хэлний хөтөлбөр
ОЛОН УЛС СУДЛАЛЫН СУРГУУЛЬ	Солонгос хэл судлалын мэргэжил	●	
	Олон улсын соёл аялал жуулчлалын мэргэжил	●	
	Глобал химийн инженерчлэл ба машин механизмын мэргэжил	●	
	Спорт, эрүүл мэндийн удирдлага мэргэжил	●	

	Глобал бизнесийн удирдлага мэргэжил		
	Урлаг, дизайны мэргэжил		
НИСЭХИЙН СУРГУУЛЬ	Нисэх онгоцны засвар үйлчилгээний мэргэжил		
	Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн мэргэжил		
	Нисэх онгоц үйлдвэрлэлийн мэргэжил		
	Хотын агаарын хөдөлгөөнт системийн мэргэжил		
ҮНДСЭН СУРГУУЛЬ	Сувилахуйн мэргэжил		
	Шүдний эрүүл ахуйн мэргэжил		
	Нисэхийн үйл ажиллагаа, удирдлагийн мэргэжил		
	Агаарын тээвэр, аялал жуулчлалын үйлчилгээний мэргэжил		
ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРГУУЛЬ	Глобал вестерн хоол үйлдвэрлэлийн мэргэжил		
	Талх нарийн боов, бэйкери, кафены мэргэжил		
	Ази хоол үйлдвэрлэлийн мэргэжил		
	Далайн хүнс, хоолны соёл, аялал жуулчлалын мэргэжил		
СПОРТЫН СУРГУУЛЬ	Спортын тэмцээний дасгалжуулагчийн мэргэжил		
	Олон нийтийн спортын мэргэжил		
ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН СУРГУУЛЬ	Үс засал, гоо сайхны мэргэжил		
	Креатив нүүр будалтын мэргэжил		

	Арьс арчилгаа, гоо сайхны бүтээгдэхүүний мэргэжил	●	
	Нийгмийн халамжийн мэргэжил	●	
	Өсвөр үеийн боловсрол, сэтгэл зүйн зөвлөгөөний мэргэжил	●	
	Сэргээн засах, эрүүл мэндийн үйлчилгээний мэргэжил	●	
	Эмийн менежментийн мэргэжил	●	
	Гэрийн тэжээвэр амьтны асаргаа, үйлчилгээний мэргэжил	●	

※ Дээрх элсэлт авах мэргэжлүүд өөрчлөгдөж болох бөгөөд өөрчлөлт гарсан тохиолдолд элсэлтийн мэдээллийг сургуулийн вебсайтад зарлан мэдэлнэ.

2

Элсэлтийн хуваарь

Ангилал	Хугацаа		Бусад
Онлайн бүртгэл ба материал хүлээн авах	1-р үе	2026.10.12.(Даваа) –10.23.(Баасан)	• Биеэр ирэх: Чоданг их сургууль , Олон улсын харилцаа боловсролын төв, • Шуудангаар илгээх: Чолланам-до Муан-гүн, Муан-ыб, Муан-ро 380 Чоданг их сургууль, Төв номын сан 501 тоот, Олон улсын харилцаа, боловсролын төв • Холбоо барих: 061-450-1575
	2-р үе	2026.11.9.(Даваа) - 11.20.(Баасан)	
	3-р үе	2026.12.14.(Даваа) – 2027.1.8(Баасан)	
	4-р үе	2027.1.18.(Даваа) - 2.19.(Баасан)	
Ярилцлагын шалгалт	Одоогоор товлөгдоогүй		•Дараа нь зарлагдана
Элсэгчдийн хариу гарах	1-р үе	2026.10.30.(Баасан)	• Элсэлтийн батламж болон сургалтын төлбөр төлөх мэдэгдэл олгох
	2-р үе	2026.11.27.(Баасан)	
	3-р үе	2027.1.15.(Мягмар)	
	4-р үе	2027.2.23.(Мягмар)	
Сургалтын төлбөр төлөх	Тусад нь мэдээлнэ		• Гванжу банкны сургуулийн албан данс • Төлбөрийн нэхэмжлэх дээрх заасан хугацаанд төлнө.

Шинээр элсэгчдийн чиглүүлэх сургалт	2027.3.8.(Даваа)	• Оюутны амьдрал, сургуулийн үйл ажиллагааны тухай танилцуулга
Хичээл эхлэх	2027.3.3.(Лхагва)	• Хичээл сонголт хийх

※ Дээрх элсүүлэх хөтөлбөрүүд болон элсэлтийн хуваарьт өөрчлөлт орж болох бөгөөд өөрчлөлт гарсан даруйд сургуулийн вебсайтад зарлан мэдээнэ

3

Тавигдах шаардлага

■ ҮНДСЭН ШААРДЛАГА

Ангилал	Үндсэн шаардлага: Гадаад улсын иргэн (БНСУ-ын Дээд боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, 7 дахь заалтын дагуу)	
Нийтлэг шаардлага	- Элсэгч болон эцэг эх нь бүгд гадаад улсын иргэн байх бөгөөд бүрэн дунд боловсрол эзэмшсэн (эсвэл 12 дугаар анги төгсөх гэж буй сурагч) байх. Эсвэл түүнтэй адилтгах боловсролын түвшинтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн хүн байна. - Элсэх өдрийн байдлаар хүчинтэй албан ёсны хэлний мэдлэгийн гэрчилгээтэй байх бөгөөд дараах шаардлагуудын аль нэгийг хангасан байна. - Солонгос хэлний түвшин ① Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (ТОPIK) 3-р түвшин буюу TOPIK IBT 3-р түвшинтэй байх; ② Нийгмийн нэгдлийн хөтөлбөр (КИР)-ийн 3-р шат буюу түүнээс дээш түвшнийг дүүргэсэн, эсвэл урьдчилсан үнэлгээний шалгалтад 61 ба түүнээс дээш оноо авсан байх; ③ Сэжун хэлний хүрээлэнгийн Солонгос хэлний Дунд-2 шат буюу түүнээс дээш түвшний сургалтыг дүүргэсэн байх. - Англи хэлний түвшин (зөвхөн англи хэлний хөтөлбөрт өргөдөл гаргагчдад хамаарна) ① TOEFL 530 (CBT 197, iBT 71); ② IELTS 5.5; ③ CEFR B2; ④ TEPS 601 оноо (NEW TEPS 327 оноо) ба түүнээс дээш; Англи хэлийг төрөлх хэл болгон ашигладаг улсын иргэн, эсвэл англи хэлтэй улсад дунд болон ахлах суршуулийн боловсрол эзэмшсэн элсэгчийг англи хэлний мэдлэгийн шаардлага хангасан гэж үзнэ.	
Шинэ элсэгч	Нийтлэг шаардлага хангасан гадаад улсын иргэн	
Шилжин элсэгч	2-р курсэд шилжин элсэх	Дотоодын болон гадаадын 4 жилийн сургалттай их сургуулийн 1-р курс буюу 2 улирал (зуны болон өвлийн улирлыг тооцохгүй) амжилттай дүүргэсэн (эсвэл дүүргэхээр төлөвлөж буй), эсвэл мэргэжлийн коллеж төгссөн (эсвэл төгсөхөөр төлөвлөж буй) гадаад улсын иргэн.
	3,4-р курсэд шилжин элсэх	Дотоодын болон гадаадын 4 жилийн сургалттай их сургуулийн 2-р курс буюу 4 улирал (зуны болон өвлийн улирлыг тооцохгүй) амжилттай дүүргэсэн (эсвэл дүүргэхээр төлөвлөж буй), эсвэл 2 эсвэл 3 жилийн сургалттай мэргэжлийн коллежийн холбогдох хөтөлбөрийг төгссөн (эсвэл төгсөхөөр төлөвлөж буй) гадаад улсын иргэн

■ Элсэгчийн шалгуур үзүүлэлт

○ Иргэншлийг хүлээн зөвшөөрөх шалгуур

- Гадаад улсын иргэн гэдэг нь БНСУ-ын иргэн биш хүнийг хэлнэ.


- Давхар иргэншилтэй хүн болон харьяалалгүй хүнийг гадаад улсын иргэн гэж үзэхгүй.

○ Боловсролын байдлыг хүлээн зөвшөөрөх шалгуур (шинээр элсэгчид хамаарна)

- Гадаад улсад байрлах сургууль эсвэл Солонгос улсад байрлах гадаадын сургуульд бага, дунд, ахлах боловсролын 12 ба түүнээс дээш жилийн бүх сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн тохиолдолд элсэх боломжтой. (Давхар иргэншилтэй хүнийг хамруулахгүй.)
- 12 жилээс бага боловсролын тогтолцоотой улсын бага, дунд, ахлах боловсролын бүх хөтөлбөрийг дүүргэсэн гадаадын иргэнийг БНСУ-ын ахлах сургуулийн төгсөгчтэй адил боловсролтой гэж хүлээн зөвшөөрнө. (Үндэслэл: Бага, дунд боловсролын тухай хуулийн 98 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт)
- 11 жилийн болон 12 жилийн боловсролын тогтолцоотой улсын бага, дунд боловсролын сүүлийн 3 жилийг тухайн улсад дүүргэсэн бол ахлах сургуулийн боловсрол эзэмшсэн гэж үзнэ. (Гэхдээ 2 буюу түүнээс дээш улсад нийтдээ 11 ба түүнээс дээш жилийн бага, дунд боловсрол эзэмшсэн байх шаардлагатай.)

4 Өргөдөл гаргах журам

□ Элсэлтийн үйл явц



○ Өргөдөл гаргагч нь сургуулийн элсэлтийн өргөдөл болон шаардлагатай баримт бичгийг тогтоосон хугацаанд заавал бүрдүүлэн ирүүлнэ. (Холбоо барих мэдээллээ тодорхой бичсэн байна.)

○ Ирүүлсэн элсэлтийн өргөдөл болон бусад материалыг буцаан олгохгүй. Харин эх хувиар нь ирүүлсэн баримт бичгийг хуулбарлан эх хувьтай тулган баталгаажуулсны дараа буцаан олгоно.

○ Бүрдүүлэх материал дутуу, ирүүлсэн материал болон бүртгэлийн мэдээлэл хуурамч болох нь тогтоогдсон, эсхүл элсэх зорилго тодорхой бус гэж үзсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.

☒ Элсэх хүсэлт гаргахад анхаарах зүйлс

- ☐ Зөвхөн нэг мэргэжил, хөтөлбөрт өргөдөл гаргах боломжтой
- ☐ Давхар бүртгэл хийхийг хориглоно.

Хэрэв хоёр буюу түүнээс дээш их, дээд сургууль (их сургууль, аж үйлдвэрийн их сургууль, багшийн их сургууль, мэргэжлийн коллеж)-д зэрэг тэнцсэн бол зөвхөн нэг сургуульд бүртгүүлэх ёстой. Давхар бүртгэл хийсэн тохиолдолд бүртгүүлсэн бүх сургуулийн элсэлтийн эрх хүчингүй болно.

☐ Шилжин суралцагчдад анхаарах зүйлс

Шилжин суралцах	3-р курс	▪Хос дипломын хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргах боломжтой бөгөөд хэлний түвшний тэтгэлэгт хамрагдана.
	4-р курс	▪Хос хэлээр хичээллэх боломжтой бөгөөд зөвхөн нэг мэргэжил сонгон суралцах боломжтой. ▪ Глобал хэлний боловсролын төвийн 300 цагийн сургалтыг заавал дүүргэнэ. ▪ Хэлний мэдлэгийн тэтгэлэгт хамрагдахгүй.

5

Сонгон шалгаруулах арга

☒ Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт ба үнэлгээ

Элсүүлэх мэргэжил	Үнэлгээний үзүүлэлт, эзлэх хувь болон оноо			Бусад
	Бичиг баримт бүрдүүлэлтийн үнэлгээ	Ярилцлага	Нийт	
Бүх мэргэжил	80%	20%	100%	

☒ Бүртгэлийн хураамж

- ☐ Бүртгэл хийгдэх үед 200,000 воны бүртгэлийн хураамж төлнө.

Ангилал	Бүрдүүлэх материал	Бусад
Нийтлэг шаардлага	① Элсэлтийн анкет (Маягт 2,3) 1 хувь ② Хувийн мэдээлэл өгөх, ашиглах зөвшөөрлийн хуудас (Маягт 4) 1 хувь ③ Хувийн танилцуулга ба суралцах төлөвлөгөө (Маягт 5) 1 хувь ④ Санхүүгийн батлан даагчийн тодорхойлолт (Маягт 6) 1 хувь ⑤ Гадаад улсын иргэншлийг нотлох баримт (эцэг, эх болон өргөдөл гаргагчийн паспортын хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар гэх мэт) ⑥ Гэр бүлийн харилцааг нотлох баримт бичиг – (Солонгос эсвэл англи хэлээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан байна.) 1 хувь ⑦ Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дүнгийн тодорхойлолт, 1 хувь ⑧ Санхүүгийн чадварыг нотлох бичиг баримт – Санхүүгийн батлан даагчийн 16,000,000 вон буюу түүнээс дээш хэмжээний хадгаламжийн үлдэгдлийн тодорхойлолт, банкны гүйлгээний хуулга зэрэг ⑨ Цээж зураг (3×4 см) – 4 хувь ⑩ Гадаад хэлний чадварыг нотлох баримт – 1 хувь	
Шилжин элсэгч	① Их сургуульд суралцаж буй тодорхойлолт болон дүнгийн тодорхойлолт тус бүр 1 хувь	

□ Элсэлтийн бичиг баримт бүрдүүлэх, илгээхэд анхаарах зүйлс

○ Дүнгийн тодорхойлолт болон төгссөн тухай диплом (эсвэл төгсөхөөр төлөвлөж буйг нотлох тодорхойлолт)-ыг доорхи хэлбэр баталгаажуулан ирүүлнэ. Гадаад хэл дээрх бүх баримт бичгийг заавал солонгос эсвэл англи хэлээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан байна.

※ Нотариатын баталгаа эсвэл консулын баталгаажуулалт: Гадаадын иргэд өөрийн улсын нотариатын байгууллага (хууль зүйн товчоо)-аар баталгаажуулсан байна.

① Апостиль (Apostille)-оор баталгаажуулсан боловсролын баримт бичиг

② Апостилийн гэрээнд нэгдээгүй улсын иргэдийн хувьд тухайн улсад суугаа БНСУ-ын консулын газар эсвэл БНСУ-д суугаа өөрийн улсын дипломат төлөөлөгчийн газрын консулын баталгаажуулалт хийлгэсэн боловсролын баримт бичиг

③ БНХАУ-ын Боловсролын яамны харьяа Боловсрол, эрдмийн зэрэг баталгаажуулах төвөөс олгосон боловсрол, эрдмийн зэргийн баталгаажуулалтын тайлан. (Зөвхөн БНХАУ-д боловсрол эзэмшсэн өргөдөл гаргагчид хамаарна.)

- Гэр бүлийн харилцааг нотлох баримт бичгийг солонгос эсвэл англи хэлээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан байна.
- Эцэг эхийн иргэний үнэмлэхийг солонгос эсвэл англи хэлээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан байна. (Зөвхөн Вьетнам улсын оюутнуудад хамаарна.)
- Эх хувьтай тулган шалгах шаардлагатай бүх баримт бичгийг эх хувьтай нь хамт ирүүлж, тулган баталгаажуулалт хийлгэнэ.
- Элсэлтийн өргөдөл болон бусад материалыг эх хувиар ирүүлэхийг үндсэн зарчим болгоно. Шуудангаар ирүүлэх тохиолдолд бүртгэлийн сүүлийн өдрийн 18:00 цаг хүртэл их сургуульд хүргэгдэн ирсэн материалыг хүчинтэйд тооцно.
- Ирүүлсэн баримт бичгүүд дээрх нэр хоорондоо зөрүүтэй бол тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон нэг хүнийх мөн болохыг нотлох баримтыг хавсаргана.
- Төгсөхөөр төлөвлөж буй өргөдөл гаргагч тэнцсэн тохиолдолд хичээл эхлэхээс өмнө төгссөн тухай албан ёсны диплом, тодорхойлолтоо заавал ирүүлнэ.
- Их сургуулиас нэмэлт материал шаардах тохиолдолд заавал бэлдэж өгөх бөгөөд ирүүлээгүй тохиолдолд элсэлтийн шалгаруулалтаас хасагдах болно.
- Элсэгчдийн тоонд хязгаарлалт хийхгүйгээр сонгон шалгаруулж болох боловч суралцахад хүндрэлтэй гэж үзсэн өргөдөл гаргагчийг элсүүлэхгүй байж болно.

7

Элсэгчийн анхаарах зүйлс

- Өргөдөл гаргагч нь шаардлагатай бүх материалыг тогтоосон хугацаанд бүрэн ирүүлэх ёстой.
- Хуурамчаар үйлдэх, засварлан өөрчлөх зэрэг зөрчил илэрсэн тохиолдолд элсэх эрх олгосны дараа илэрсэн байсан ч тэнцсэн шийдвэр болон элсэлтийг хүчингүй болгоно.
- Өргөдлийн маягтад холбоо барих мэдээлэл (хаяг, утасны дугаар)-ийг буруу бөглөсөн эсвэл холбоо тогтоох боломжгүй болсон тохиолдолд элсэлтийн дүнтэй холбоотой мэдэгдлийг хүргэх боломжгүй болж, элсэлтийн эрх хүчингүй болж болзошгүй. Иймд холбоо барих мэдээлэл өөрчлөгдвөл Олон улсын харилцаа, боловсролын төвийн (061-450-1575 дугаарт) нэн даруй мэдэгдэх шаардлагатай.
- Элсэлтийн үнэлгээний дэлгэрэнгүй агуулгыг нийтэд мэдээлэхгүй бөгөөд өргөдлөө буцаан татах, эсвэл сонгосон мэргэжлээ өөрчлөх боломжгүй.
- Ирүүлсэн баримт бичгийг буцаан олгохгүй бөгөөд холбогдох журмын дагуу Чоданг их сургуульд хадгална.
- Тэнцсэн элсэгч нь холбогдох байгууллагаас виз авч, тогтоосон журмын дагуу БНСУ-д нэвтрэн орж ирсэн байх ёстой.
- 2021 оны 3 дугаар сараас эхлэн гадаад оюутнууд БНСУ-д нэвтэрснээс хойш 6 сарын дараа Үндэсний эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах ангилалд багтана.
- Элсэлтийн өргөдлийг солонгос эсвэл англи хэлээр бөглөнө.

8

Сургалтын төлбөрийн буцаан олголт

- Хугацаа: Бүртгэл хийснээс хойш тухайн улирлын хичээл эхлэх өдрийн өмнөх өдөр хүртэл
- Холбоо барих: Олон улсын харилцаа, боловсролын төв (061-450-1575)
- Төлбөр буцаан олгох боломжтой нөхцөл: Бүртгэл хийсний дараа хувийн шалтгаанаар элсэхээс татгалзсан тохиолдолд , виз олгохоос татгалзсан, эсвэл БНСУ-д нэвтрэх боломжгүй болсон тохиолдолд
- Бүрдүүлэх материал: тус их сургуулийн сургалтын төлбөр төлсөн баримтын эх хувь – 1 хувь , сургалтын төлбөрийн буцаалт хийх өргөдөл (их сургуулийн маягт) – 1 хувь , өргөдөл гаргагч эсвэл хууль ёсны төлөөлөгчийн иргэний үнэмлэх (эсвэл паспорт)-ын хуулбар – 1 хувь

9

Бусад мэдээлэл

Энэхүү элсэлтийн журамд заагаагүй бусад асуудлыг тус их сургуулийн элсэлтийн албаны шийдвэрээр зохицуулна

Хууль бус, шударга бус аргаар тэнцсэн буюу элссэн нь тогтоогдвол элссэний дараа илэрсэн тохиолдолд тэнцсэн шийдвэр болон элсэлтийг хүчингүй болгож, зөрчил гаргасан этгээд болон холбогдох хүмүүст хуулийн дагуу хариуцлага тооцож, эрх бүхий байгууллагад шилжүүлэх болно.